

БАТЛАВ. ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
ЭРХЭЛСЭН ПРОРЕКТОР

Б.ДАВААСҮРЭН



ТҮРЭЭСЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАР

Түрээслэх эд хөрөнгийн танилцуулга:

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Их сургуулийн гудамж, МУИС-ийн Хичээлийн болон оюутны байруудад Өөртөө үйлчлэх вендинг машины үйлчилгээ авах зориулалтаар талбай түрээслүүлнэ.

Сонгон шалгаруулалтын ерөнхий мэдээлэл:

Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацаа	Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацаа 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 10 цаг 00 минут хүртэл авна. /хугацаа хоцорсон материал хүлээн авахгүй/
Материал хүлээн авах хаяг	МУИС, Хичээлийн 1-р байр, 2 давхарт, 205 тоот өрөө, байгууллагын бичиг хэргийн ажилтанд. Утас: 75754400 (1602, 1213)
Материал нээх хугацаа, хаяг байршил	Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо МУИС-ийн Хичээлийн 1 дүгээр байр 320 тоот өрөө Нээлтэд оролцох хүсэлтэй оролцогчдыг байлцуулан материалыг 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.
Эд хөрөнгө түрээслэх үнийн доод хэмжээ, талбайн м ²	Хичээлийн 1,2,5,7,8-р байр, номын сан, Монгол Япон төвийн 1-р давхар, хичээлийн 2-р байрны 3-р давхар, оюутны 1,2,3,4,5,6-р байрны 1-р давхарт тус бүр 4м.кв талбай. Нэг м ² талбайн түрээслүүлэх доод үнэ 35,000.00 (гучин таван мянга) төгрөг.
Түрээслэгч үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийн мэдээлэл	Үндсэн үйл ажиллагааны чиглэл нь хүнсний үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхэлдэг байна.
Түрээслэгчийг сонгон шалгаруулах зааврын талаарх товч мэдээлэл	<ul style="list-style-type: none">Сонгон шалгаруулалтын материалыг тогтоосон хугацаанд битүүмжлэн эх болон хуулбар хувийг ирүүлнэ.Бүрдүүлсэн материалын жагсаалтыг дугтуйны гадна талд бичсэн байна.Иргэн, хуулийн этгээд нь: Хичээлийн 1,2,5,7,8-р байр, номын сан, Монгол Япон төвийн 1-р давхар, хичээлийн 2-р байрны 3-р давхар, оюутны 1,2,3,4,5,6-р байрны 1-р давхарт тус бүр 4м.кв талбайг Өөртөө үйлчлэх вендинг машины үйлчилгээний зориулалтаар ажиллуулах үйл ажиллагааны танилцуулга,Монгол Улсын стандарт, тусгай зөвшөөрөл, шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байх, техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлын үзүүлэлт ирүүлнэ.Сонгон шалгаруулалтад оролцогч нь эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнээр үйлчлэх тухай, мөн гэрээний нэхцэлүүдийг зөвшөөрч буй талаар мэдэгдэл, албан бичиг ирүүлнэ.Оролцогч нь сонгон шалгаруулалтыг нээхээс өмнө татгалзах саналаа ирүүлж болно.
Оролцогчдын бүрдүүлж ирүүлэх материал	Оролцогчид дараах материал бүрдүүлж ирүүлнэ:

- Талбай болон үндсэн хөрөнгө түрээслэх үнийн санал албан бичгээр ирүүлэх;
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ (иргэний хувьд цахим үнэмлэх), эрх бүхий байгууллагаас олгосон үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хуулбар;
- Үйл ажиллагааны танилцуулга;
- Ажлын туршлагын талаарх мэдээлэл 2024 оноор (хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалт, гэрээний хуулбар);
- Санхүүгийн чадварыг нотлох баримт 2024 оноор (иргэн бол харилцагч банкны тодорхойлолт, сүүлийн 1 жилийн дансны хуулга, хуулийн этгээд бол сүүлийн 1 жилийн тайлан, татвар, нийгмийн даатгалын тодорхойлолт);
- Гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд 1 сарын төлбөртэй тэнцэх хэмжээний барьцаа төлбөрийг МУИС-ийн дансанд байршуулах;
- Ажиллах хүчиний мэдээлэл, мэргэжлийн диплом, үнэмлэхийн хуулбар;
- Татварын байгууллагын цахим тодорхойлолтыг бар кодын хамт ирүүлэх; /Тендер нээсэн өдрөөр өр төлбөргүй байх, өртэй бол татгалзах үндэслэл болно/;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын болон харьяа шүүхийн байгууллагаас зарга маргаанд холбогдолгүй талаарх албан бичиг ирүүлэх;
- Худалдан борлуулах бараа бүтээгдэхүүний нэр, төрөл, үнийн санал, жагсаалтыг ирүүлэх;
- Түрээсийн төлбөрөө 3 /гурав/ сараар урьдчилан төлөх санхүүгийн чадвартай, хөрөнгийн баталгаатай байх (холбогдох эрх бүхий байгууллагын баталгаа гаргуулах зэрэг);
- Аливаа эрсдэл, даатгалыг оролцогч тал бүрэн хариуцах албан бичиг ирүүлэх;

Түрээслүүлэх хөрөнгийн талаар мэдээлэл авах:

Түрээслүүлэх байр, талбайг өмч эзэмшигч МУИС-ийн Хичээлийн болон оюутны байрууд дээр очиж үзэж болох бөгөөд сонгон шалгаруулалтын заавар, бүртгэх хугацаа зэрэг мэдээллийг 75754400/1213/ утсаар авна уу.

Хаяг: СБД, 6-р хороо, Их сургуулийн гудамж 1, МУИС, Хичээлийн 1-р байр, 1 давхарт, 122 тоот.